



**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2020 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 81

Сайншанд сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/23 дугаар тогтоолоор батлагдсан “Хурлын даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1, 2.2.10 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын гарын бэлэг худалдан авахад хөрөнгө зарцуулсугай.
2. Гарын бэлэг бэлтгэх зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
3. Дээрх зардалд шаардагдах 4150000 /дөрвөн сая нэг зуун тавин мянга/ төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг төсвийн шууд захирагч /Ц.Батсугир/, нягтлан бодогч /Б.Наранцацрал/ нарт тус тус зөвшөөрсүгэй.

ДАРГА

Б. ГАНЗОРИГ

